



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АУДИТЫН НЭР: “ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”**



**“Аймгийн төвийн Баян-Өндөр сумын санхүүгийн алба нь программ хангамжгүйгээс үндсэн чиг үүргийн дагуу ажиллаагүй, Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна”**

Орхон аймаг  
2018 он

## АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....	3
Орхон аймаг дахь Төрийн аудитын газар:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, стандартын талаарх мэдэгдэл.....	4
Дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Үндсэн мэдээлэл.....	6
Аудитын менежер: Б.Эрдэнэ	<b>БҮЛЭГ А. Аймгийн төвийн Баян-Өндөр сумын санхүүгийн алба нь программ хангамжгүйгээс үндсэн чиг үүргийн дагуу ажиллаагүй байна.</b>	
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн	А.1 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, тогтоомж бусад эрх зүйн актуудын хоорондын уялдаа холбоо дутмаг байна.	7
Аудитор: Т.Болормаа	А.1.1 Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг холбогдох хуульд бүрэн тодорхойлсон байна.	7
	А.1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжуудад бусад эрх зүйн актуудад тусгагдсан харилцах дансыг хаах талаархи зохицуулалтууд хэрхэн үйлчлэх, яаж зохицуулах талаар тодорхой тусгагдаагүй байна.	7
	А.2 Төрийн сангийн үйл ажиллагаанд хараат бус байдлыг хэрхэн хангах талаар зохицуулаагүй, аймгийн төвийн сумын санхүүгийн алба нь төлбөр тооцоо гүйцэтгэх программгүйгээс үндсэн чиг үүргийнхээ дагуу ажиллаагүй байна.	8
	А.2-1 Төрийн сангийн үйл ажиллагааны талаар журам зааварт хараат бус байдлыг хангаж ажиллах талаар тодорхой тусгаагүй, дүрэм журмын зарим зохицуулалт оновчтой бус байна.	9
	А.2-2 Баян-Өндөр сумыг төрийн сангийн төлбөр тооцооны программтай болгож, чиг үүргийн дагуу ажиллуулаагүй, ажлын ачааллыг тэнцвэржүүлээгүй байна.	11
	А.3 Төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц байгаа боловч ажлын байрны тодорхойлолтыг жишиг зааварт нийцүүлээгүй, сумын нягтлан бодогчийг албаны даргын ажилд давхар томилсон нь хяналт алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	12
2018 оны 11 дүгээр сар	А.3-1 Ажлын байрны тодорхойлолтыг жишиг зааварт нийцүүлэн боловсруулаагүй байна.	12
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар 70353088, 70350757, 70355805 дугаарын утсаар харилцана уу.	А.3-2 Жаргалант сумын санхүүгийн албаны нягтлан бодогчийг албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр давхар томилсон нь ажлын хяналт алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	13
	А.4 СТСХ-н 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө буюу СТСХ-н даргын үр дүнгийн гэрээний биелэлт 92.0 хувьтай дүгнэгдсэн байна.	13
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. /www.audit.mn/	<b>БҮЛЭГ Б. Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй, хяналтын үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.</b>	
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	Б.1 Төрийн сангийн төлбөр тооцоог хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа боловч алдаа, дутагдал гарсан байна.	15
	Б.1-1 Гүйлгээ хүлээн авах цагийн хуваариас шалтгаалан төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх нөхцөлийг хязгаарласан, төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	15
	Б.1-2 Аймгийн төрийн сан нь харилцах данс болон кассын дансны үлдэгдлийг бүрэн тооцоо нийлээгүй, төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсын үндэслэх баримтыг тулгаж хянасан талаарх тэмдэглэлийг хийгээгүй байна.	17
	Б.1-3 Төсвийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд холбогдох ажилтнуудын ажлын хариуцлага сул, тэдгээрт тавих хяналт хангалтгүй байна.	18
Орхон аймаг	Б.2 ЗГСУМС нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.	19
	Б.2-1 Системийг хэрэглэхэд ойлгомжтой боловч зарим нэг дутагдалтай тал байна.	19
	Б.2-2 ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үг шилжүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулаагүй байна.	21
	Б.3 Дотоод хяналтын үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.	23
	Б.3-1 Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулсан боловч хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.	23
	Б.3-2 Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.	24
	ДҮГНЭЛТ:.....	25
	ЗӨВЛӨМЖ:.....	26
	Холбогдох байгууллагын санал.....	27
	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаал.....	28
	Хавсралт.....	30

[illegible]

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:****Аудит хийх үндэслэл**

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө болон Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлээ.

**Аудитын зорилт**

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
2. Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитыг Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд аймаг, сумын төрийн сан, зарим төрийн байгууллагууд хамрагдлаа.

**Аудитын арга зүй**

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудит хийсэн бүрэлдэхүүн**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, санхүүгийн аудитын багийн ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Т.Болормаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**Аудитад  
ашигласан  
шалгуур**

Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хуулиуд

Засгийн газрын тогтоол:

- Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай – 2013
- Санхүүгийн алба байгуулах тухай – 2014
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам – 2015

Сангийн сайдын тушаал:

- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-2012
- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам – 2012
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам – 2013
- Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам – 2013
- Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам – 2014
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам – 2014
- Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар – 2015
- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам – 2016
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам зэрэг болно.

**Аудитын тайлан,  
баталгаажуулалт:**

Аудитыг 2018 оны 9 сарын 06-ны өдрөөс 11 дугаар сарын 5-ны хооронд хийж гүйцэтгэн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлээ.

### Ерөнхий мэдээлэл

Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төрийн байгууллага үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах, санхүүгийн эх үүсвэрийг хуримтлуулах, хуваарилж зарцуулах, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын төлөвлөгөөг боловсруулах, хянах, батлуулах, гүйцэтгэлийг хангах, биелэлтэд нь хяналт тавих ажлыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцах үүрэг бүхий аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн нэгж бөгөөд дотроо төсөвт байгууллагын орлого, зарлагын гүйлгээг хийх, төсвийн зарцуулалтад хяналт тавих зорилго бүхий Төрийн сантай байна.

Аймгийн татварын орлогын төлөвлөлт, татвар хураалтын ажлын зохион байгуулалтын талаар бодлогын удирдамж, чиглэлээр хангах, татварын орлогын төлөвлөгөөний биелэлт, татварын өрийн барагдуулалтад хяналт тавих, Засаг даргыг мэдээллээр хангах.

Аймгийн төсвийн зарлагыг нэг жил болон дунд хугацаагаар үнэн зөв, оновчтой төлөвлөж батлуулах, орон нутгийн төсвийн хүрээг тодорхойлж, Сангийн яаманд хүргүүлэх.

Аймгийн төсвийн байгууллагын төсвийн төслийг хүлээн авч хянан нэгтгэн боловсруулах, ИТХ-аар батлуулах бэлтгэлийг хангах, хуваарилах, гүйцэтгэлд хяналт тавих, тооцоо судалгаа, үнэлгээ хийх.

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнах.

Аймгийн төсөвт байгууллагуудын орлого, зарлагын гүйлгээг хийж, төсвийн зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих, гүйцэтгэлийг сар, улирлаар тооцон мэдээлэл боловсруулах, холбогдох газарт хүргүүлэх.

Санхүүгийн тайлан тэнцлийг хагас, бүтэн жилээр гарган тогтоосон хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх.

Их засвар, хөрөнгө оруулалт, нөөц сан, орон нутгийн бусад зардал, хуваарилагдаагүй орлогын дансыг хариуцан баримтын бүрдлийг хангах, гүйлгээ хийх, гүйцэтгэлд хяналт тавих.

Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төрийн сангийн орлого, зарлагын гүйлгээг хянах, төсвийн байгууллага, аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн, тэдгээрийг арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

Орхон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь нь орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 81, босоо тогтолцоотой 28 байгууллага, тусгай сангийн нийт 109 байгууллага, төсөл тусгай сангийн төлбөр тооцооны гүйлгээг гүйцэтгэж байна.



**БҮЛЭГ А. Аймгийн төвийн Баян-Өндөр сумын санхүүгийн алба нь программ хангамжгүйгээс үндсэн чиг үүргийн дагуу ажиллаагүй байна.**

***А.1 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, тогтоомж бусад эрх зүйн актуудын хоорондын уялдаа холбоо дутмаг байна.***

**А.1.1 Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг холбогдох хуульд бүрэн тодорхойлсон байна.**

Төсвийн тухай хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд Төрийн сангийн нэгдсэн данс, Төрийн сангийн тогтолцоо, Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг, Төв төрийн сангийн чиг үүргийг тус тус тодорхойлсон байна.

Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулах талаар Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326, 2015 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 426, “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” батлах тухай 24 –р тогтоол батлагдсан.

Мөн Сангийн сайдын тушаалаар батлагдсан 2012 оны “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” 276, “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам” 194, 2013 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам” 73, “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам” 24/24/А-9, 2014 оны “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам” 65, “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар” 55, “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам” 95, 2015 оны “Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд дагаж мөрдөх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 129, 2015 оны “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” 90, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 7, 2016 оны “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, заавар” 431 зэрэг журам, зааврууд батлагдаж гарсан байна.

**А.1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжуудад бусад эрх зүйн актуудад тусгагдсан харилцах дансыг хаах талаархи зохицуулалтууд хэрхэн үйлчлэх, яаж зохицуулах талаар тодорхой тусгагдаагүй байна.**

Төсвийн тухай хуулийн 8.5.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан байдаг.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт нь Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст шилжсэн боловч аймгийн төсвийн төслийг

нэгтгэж ИТХ-д өргөн барих үүрэг нь Засаг даргын санхүүгийн асуудал хариуцсан нэгж болох СТСХ-т байдаг. Гэтэл Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь төлөвлөлтөө цаг тулгаж ирүүлж байгаа нь Хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй бүрэн танилцаж, хянаж ИТХ-д оруулах боломжгүй болгож байна.

Иймд аймаг, орон нутагт СТСХ хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хянаж, нэгтгэх цаглабарыг тодорхой болгох шаардлагатай байна.

Төсвийн байгууллагуудын санхүүжилт, үйл ажиллагаа, удирдлагын шийдвэр гаргалттай холбоотойгоор татвар, нийгмийн даатгалын байгууллагад салбар хамарсан их хэмжээгээр өр төлбөр үүсэх, ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдоод ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний цалинг гаргуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар гүйцэтгүүлэх зэрэгт тус тусын хууль, тогтоомжид тодорхойлсон дараах заалтууд хэрхэн зохицуулагдах нь ойлгомжгүй, аль аль талын хууль тогтоомжуудад тодорхой тусгагдаагүй байна. Үүнд:

Татварын ерөнхий хуулийн 28.1.7-д “тогтоосон хугацаанд татвар төлөөгүй хуулийн этгээдийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох”, 63.1-д “Хугацаанд нь төлөөгүй татварын өрийг эхний ээлжинд татвар төлөгчийн банкин дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах бөгөөд уг мөнгөн хөрөнгө нь татварын өрийг төлөхөд хүрэлцэхээргүй бол уг данснаас төлөх баталгаажсан барьцаа, шүүхийн шийдвэртэйгээс бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож, дансны орлогоос татварын өрийг барагдуулна”,

Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2-д “тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг шимтгэлээ төлж дуустал түр зогсоох”,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 50 дугаар зүйлд тодорхойлсон “Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх” харилцааг зохицуулсан заалтууд мөн хуулийн 93.2-д “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч-хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна” гэсэн заалтууд.

Дээрхи хуулиудад тусгагдсан байгууллагын харилцах дансны зарлагын гүйлгээг хязгаарласан зохицуулалтыг хэрхэн шийдвэрлэх, яаж хэрэгжүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид зохицуулалт хийх нь зүйтэй байна.

***А.2 Төрийн сангийн үйл ажиллагаанд хараат бус байдлыг хэрхэн хангах талаар зохицуулаагүй, аймгийн төвийн сумын санхүүгийн алба нь төлбөр тооцоо гүйцэтгэх программгүйгээс үндсэн чиг үүргийнхээ дагvv ажиллаагvй байна.***



**А.2-1 Төрийн сангийн үйл ажиллагааны талаар журам зааварт хараат бус байдлыг хангаж ажиллах талаар тодорхой тусгаагүй, дүрэм журмын зарим зохицуулалт оновчтой бус байна.**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т “Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас тогтоох бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хэлтэс, тасагтай байна” гэж тодорхойлсон.

Төсвийн тухай хуулийн 36.2-д “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна” гэжээ.

Аймгийн Засаг даргын 2009 оны 214 дугаар захирамжийн 5-р хавсралтаар баталсан Санхүү, төрийн сангийн хэлтсийн дүрэмд Санхүү төрийн сангийн хэлтэс нь ... үүрэг бүхий аймгийн ЗДТГ-ын үндсэн нэгж мөн. Хэлтэс нь дотроо төсөвт байгууллагуудын орлого, зарлагын гүйлгээ хийх, төсвийн зарцуулалтад хяналт тавих зорилго бүхий Төрийн сантай байна гэж тусгажээ.

Монгол улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоол гарснаар Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцийг 7 хэлтэс /цэргийн штаб ороод/ 41 хүртэл орон тоотойгоор байхаар тогтоосон бөгөөд үүний нэг хэлтэс нь СТСХ бөгөөд одоогоор 9 ажилтантай ажиллаж байна. Мөн сумдын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нь ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдож, чөлөөлөгдөж ЗДТГ-ын бүтцэд багтан ажиллаж байна.

Төрийн сангийн нэгж нь ЗДТГ дотроо харьяалагддаг, ЗДТГ-ын дарга томилж чөлөөлж, үр дүнгийн гэрээг дүгнэж байгаа нь төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтний төсвийн зарлагын хяналт хэрэгжүүлэх, бие даасан, хараат бус байдал алдагдахад нөлөөлж болохуйц байна.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.2-д “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно” , 2.3-т Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно” гэж заасан байна.

Гэтэл тус журмын 6.3-д “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна”, 6.4-д “Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээг төсвийн жил эхэлмэгц эхний сард багтаан Төрийн сангийн газрын санхүүжилт

тайлан бүртгэлийн хэлтэс, орон нутаг дахь төсвийн байгууллагыг тухайн орон нутгийн төрийн сангийн нэгж баталж эрхийг нээнэ” гэсэн бас заалт байгаа юм.

Төсвийн байгууллагууд зардлын эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргадаг тул жижиг мөнгөн санг эхлээд хэрхэн бий болгох буюу аль зардлаас эрх нээлгэж касс т мөнгө татах авах, хэрхэн хэрэглэх талаар нягтлан бодогч нар ойлголт муутай байна.

Тиймээс одоогоор төсвийн байгууллагууд жижиг мөнгөн сан үүсгэдэг тохиолдол байхгүй бөгөөд зайлшгүй бэлэн мөнгөөр гүйлгээ хийх хэрэг гарвал зардал болох тухайн үед нь Төрийн банкн дахь картын /кассын/ дансаараа дамжуулан гүйцэтгэх, ихэвчлэн мөнгөн хөрөнгө зарцуулагдсаны дараа нөхөн авах, бэлнээр хүлээн авсан орлогыг Төрийн сангийн бүртгэлийн дансандаа тухай бүр тушаалгүй зарцуулах, зарцуулсан мөнгийг эргэн нөхөх зэргээр зохицуулж, хууль тогтоомж зөрчигдөхөд хүргэж байна.

Аймгийн ИТХ, ЗДТГ нь тэмдэглэлт баяр ёслол, арга хэмжээтэй холбоотойгоор бэлэн мөнгөний хэрэгцээ гардаг бөгөөд Төрийн сангийн харилцах данснаас бэлэн мөнгө татахдаа зардал гаргаж буй мэтээр баримт бүрдүүлж гүйлгээ хийдэг тул харилцах данснаас Төрийн банкн дахь картын данс буюу кассын дансандаа мөнгө шилжүүлж бэлнээр зарцуулахдаа кассын орлого зарлагын данс бүртгэл хөтлөөгүй, харилцахаас гүйлгээ хийсэн төлбөрийн хүсэлтийн баримтаар /зарим баримтыг харилцахдаа үлдээсэн/ кассын тайлан гаргадаг, тус картын дансан дахь бэлэн мөнгөний зарцуулалт баримтаар бүгд бүрэн дэмжигдэж нотлогдохгүй зарцуулалтын хяналт, анхан шатны баримт бүрдүүлэлт алдагдахад хүргэж байна.

Сангийн сайдын 2015 оны 90 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” -ын дагуу бүртгэлийн мэргэжилтэн ерөнхий нягтлан бодогч болон дотоод хяналтын мэргэжилтнийг, ерөнхий нягтлан бодогч бүртгэлийн мэргэжилтэнг, дотоод хяналтын мэргэжилтэн төсвийн мэргэжилтнийг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлож байхаар тусгасан байна.

Бүртгэлийн мэргэжилтэн нь ЗГСУМС-д нэвтрэх эрх байдаггүй, тус системд орж ажилладаггүй тул ерөнхий нягтлан бодогч болон, дотоод хяналтын мэргэжилтнийг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох, гүйлгээ баталгаажуулах нь зохимжгүй юм.

Манай аймгийн хувьд бүртгэлийн мэргэжилтэн нь аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад, төсөл хөтөлбөрийн данс болон Эрдэнэт сан, Авто замын сангийн нягтлан бодогчийн ажлыг давхар гүйцэтгэж төлбөрийн хүсэлтэд 2-р гарын үсэг зурдаг тул ажлын ачааллын хувьд ч, өөрөө өөрийнхөө гүйлгээг баталгаажуулахын хувьд ч тэр ерөнхий нягтлан болон дотоод хяналтын ажилтанг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох нь боломжгүй юм.

Тиймээс ерөнхий нягтлан бодогч болон дотоод хяналтын мэргэжилтэн нар харилцан бие биенээ орлох байдлаар ажиллаж ирсэн байна.

**А.2-2 Баян-Өндөр сумыг төрийн сангийн төлбөр тооцооны программтай болгож, чиг үүргийн дагуу ажиллуулаагүй, ажлын ачааллыг тэнцвэржүүлээгүй байна.**

Аймгийн Төрийн сан дээр орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 81, босоо тогтолцоотой 28 байгууллага, тусгай сангийн нийт 109 байгууллага, төсөл тусгай сангийн төлбөр тооцооны гүйлгээг төлбөр тооцооны 3 мэргэжилтэн гүйцэтгэж байгаа нь төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх, баталгаажуулах ачаалал бусад аймагтай харьцуулахад өндөр байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/06 тушаалаар аймгийн ЗДТГ-ын орон тоог батлахдаа ажлын байрны тодорхойлолт болон өдөр тутамд гүйцэтгэж буй ажил, чиг үүрэг нь нэг ижил 3 төрийн сангийн мэргэжилтний 1-ийг ТҮ-ний ангиллаар баталсан нь Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг тогтоох тухай” 354-р тогтоолыг зөрчиж байна.

Засгийн газрын 2014 оны 326-р тогтоолоор сумдад Санхүүгийн алба байгуулагдаж суманд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг сумын ЗДТГ-ын санхүүгийн албанд шилжүүлсэн.

Тус тогтоолоор сумын ИТХ, ЗДТГ, сургууль, цэцэрлэг 2 хүртэл, эмнэлэг, соёлын төв, ОНХС, тусгай сангуудыг хариуцсан 2 нягтлан бодогчтой байх, хэрэв үүнээс олон төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг бол 3-5 байгууллагын дунд нэг нягтлан бодогчтой байхаар нормчилсон байдаг. Гэтэл аймгийн төвийн суманд байгууллага бүр тусдаа нягтлан бодогчтой байгаа нь нягтлан бодогчдын ажлын ачааллыг харилцан адилгүй болгож, тогтвор суурьшилтай ажиллахад нөлөөлж байна.

Санхүүгийн албаны бүтэц бий болсноор

- Нягтлан бодогчдын ажлын ачаалал нэмэгдэж, байгууллага дээр бүртгэлээр тавих өдөр тутмын хяналт сулрах, өмч хөрөнгө эзэнгүйдэх, шамшигдах эрсдэл бий болох

- Байгууллагын удирдлагын зүгээс нягтлан бодогчийг үүрэг даалгавраар хангах, хариуцлага хүлээлгэх боломжгүй болох зэрэг хүндрэлтэй асуудлууд үүсч байна.

Аймгийн төвийн буюу Баян-Өндөр суманд санхүүгийн алба байгуулагдаж санхүүгийн албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтэн нар 2015 оны 11 сараас эхлэн ажилласан боловч төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх програм хангамжийн асуудал шийдэгдээгүй тул гүйлгээ хийгддэггүй, одоог хүртэл чиг үүргийн дагуу ажиллах нөхцөл бүрдээгүйгээс шалтгаалан сумын ЗДТГ-ын бусад албан хаагчдын зарим чиг үүргийн ажлыг гүйцэтгэдэг байна.

Тухайлбал өдөр тутамдаа Баян-Өндөр сумын санхүүгийн албаны дарга нь сумын ОНХС хариуцсан нягтлан бодогчийн ажлыг, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь сумын ЗДТГ-ын туслах нягтлан бодогчийн буюу ЗДТГ-ын татвар, нийгмийн даатгалын тайлан, шилэн данс зэрэг чиг үүргийн ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэвч Баян-өндөр сумын ЗДТГ-аас аймгийн СТСХ-т болон Сангийн яаманд төрийн сангийн төлбөр тооцооны программын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Иймд санхүүгийн албаны 2 ажилтанг чиг үүргийн дагуу ажиллах боломжийг хангах талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

***А.3 Төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц байгаа боловч ажлын байрны тодорхойлолтыг жишиг зааварт нийцүүлээгүй, Жаргалант сумын нягтлан бодогчийг албаны даргын ажилд давхар томилсон нь хяналт алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.***

**А.3-1 Ажлын байрны тодорхойлолтыг жишиг зааварт нийцүүлэн боловсруулаагүй байна.**

Орхон аймагт Төрийн сангийн нэгж нь аймгийн ЗДТГ-ын дэргэд болон Баян-өндөр, Жаргалант сумын ЗДТГ-ын бүтцэд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн болон сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоол болон Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-тай харьцуулан үзэхэд аймгийн СТСХ-ийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт Сангийн сайдын 2015 оны 90-р тушаалаар батлагдсан жишиг зааврын дагуу боловсруулагдаагүй, шинэчлэж өөрчлөгдөөгүй, ээлжийн амралттай, түр чөлөөтэй, албан томилолттой үед хэрхэн орлох талаар зохицуулагдаагүй байна.

Тухайлбал аймгийн СТСХ-ийн даргын ажлын байрны тодорхойлолт 2009 онд батлагдсан тул 2015 онд батлагдсан жишиг зааврын 1.1.4, 1.1.6, 1.1.7, 1.1.8, 1.1.9, 1.1.10, 1.1.13, 1.1.14, 1.1.15, 1.1.16 дахь заалтууд тусгагдаагүй байна.

Мөн дотоод хяналтын мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод журмын 1.5.9, 1.5.11, 1.5.12 дахь заалтууд болон гүйлгээ баталгаажуулах заалтыг тусгаагүй байхад ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтод гүйлгээг хянаж гүйлгээ хийх, зөвшөөрөл олгох талаар тусгагдсан, бүртгэлийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланг хянан хүлээн авч, аймгийн нэгдсэн тайлан, мэдээнд нэгтгүүлэх, харилцах дансны үлдэгдлийг хагас, бүтэн жилээр тулган баталгаажуулах талаархи заалтууд тусгагдаагүй байна.

Жаргалант сумын ажлын байрны тодорхойлолт нь 2014 оны 326 дугаар тогтоолоор баталсан санхүүгийн албаны чиг үүргийн жишигт нийцүүлж хийгдсэн бөгөөд 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан сумын санхүүгийн албаны ажил үүргийн жишиг зааврын зарим зүйл заалтууд огт тусгагдаагүй байна.

Тухайлбал 2015 оны 90 дүгээр тушаалд тусгагдсан 2.2.5, 2.2.7, 2.2.8, 2.2.12, 2.2.13 дахь заалтууд ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй байна.

Иймд дээрхи журам зааварт нийцүүлэн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

Баян-өндөр сумын ажлын байрны тодорхойлолт нь 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан жишиг зааварт нийцсэн бөгөөд зүйл заалт бүрээр тодорхой тусгаж өгсөн байна.

Гэвч 2 сумдын ажлын байрны тодорхойлолтыг ажилтны үр дүнгийн гэрээтэй уялдуулан үзэхэд ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан асуудлууд үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй байх тул цаашид ажлын байрны тодорхойлолттой үр дүнгийн гэрээг уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

**А.3-2 Жаргалан сумын санхүүгийн албаны нягтлан бодогчийг албаны даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгчээр давхар томилсон нь ажлын хяналт алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.**

Монгол улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоолоор Орхон аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг 7 хэлтэс /цэргийн штаб ороод/ 41 хүртэл орон тоотойгоор байхаар тогтоосон бөгөөд үүний нэг хэлтэс нь СТСХ байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2017 оны А/07 тоот тушаалаар аймгийн ЗДТГ-ын ажил албан тушаалын жагсаалтыг баталж СТСХ-ийг 9 орон тоотой байхаар тогтоосон ба төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхцаагүй байна.

Жаргалант сумын ЗДТГ-ын санхүүгийн алба нь санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч 3, нийт 5 орон тоотой ажиллаж байна. Анх санхүүгийн албыг 2015.01.05-ны өдрийн Б/03 тоот тушаалаар байгуулахдаа 2 нягтлан бодогчтой байхаар баталсан байна. Харин 2016 онд төрийн сангийн мэргэжилтэнг нягтлан бодогч болгосноор 3 нягтлан бодогчтой болсон байна. Энэ нь ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.1-д заасан нягтлан бодогчийн нормативыг зөрчсөн байна. Мөн Жаргалант сумын сургууль, соёлын төвийг хариуцдаг нягтлан бодогчийг Жаргалант сумын ЗДТГ-ын даргын 2018.08.09-ны өдрийн Б/25 тоот тушаалаар санхүүгийн албаны даргын ажлыг түр орлон гүйцэтгэгчээр томилж, ОНХС давхар хариуцуулсан нь хяналтыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Иймд төрийн сангийн төлбөр тооцооны ажлыг хяналт алдагдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж бүтэц зохион байгуулалтыг оновчтой байдлаар зохион байгуулах шаардлагатай байна.

**А.4 СТСХ-н 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө буюу СТСХ-н даргын үр дүнгийн гэрээний биелэлт 92.0 хувьтай дүгнэгдсэн байна.**

Аймаг сумдын төрийн сангийн албаны дарга болон мэргэжилтнүүд ЗДТГ-ын даргатай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулж хагас бүтэн жилээр дүгнүүлж ажилладаг байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын үр дүнгийн гэрээний нийт, ажил үйлчилгээний “Төрийн сангийн үйлчилгээ” хөтөлбөрийн хүрээнд “Төрийн сангийн тогтолцоог бэхжүүлж, төсвийн зарцуулалтын хяналтыг сайжруулах, төсвийн байгууллагуудын дансны орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, төлбөр тооцоог хянаж баталгаажуулах” гэсэн арга хэмжээ тусгагдсан бөгөөд биелэлт бүрэн 30 оноогоор дүгнэгдсэн байна.

Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн ажилтнуудын 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлт дараах байдалтай байна.

№	Овог нэр	Албан тушаал	Гэрээний биелэлт
1	Н.Бямбацэцэг	СТСХ-ийн дарга	92
2	О.Энхбаяр	Төсвийн төлөвлөлт, зарлага хариуцсан ахлах мэргэжилтэн	97.3
3	П.Энхжаргал	Бүртгэлийн мэргэжилтэн	94.2
4	М.Алтангэрэл	Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	86.0
5	Л.Галсансайнхувьт	Дотоод хяналтын мэргэжилтэн	90.8
6	Б.Мөнхцэцэг	Төрийн сангийн мэргэжилтэн	94.0
7	Б.Оюуннасан	Төрийн сангийн мэргэжилтэн	90.25
8	Э.Цэн-Аюуш	Төрийн сангийн мэргэжилтэн	90.25
9	С.Энхтүвшин	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	97.3

Үр дүнгийн гэрээнд тусгагдсан асуудал болон дүгнэсэн байдлыг үзэхэд Жаргалант сумын төрийн сангийн албаны даргын үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажил үйлчилгээнүүд нь 2015 оны 90 дүгээр тушаалын жишиг зааварт заасан заалтуудыг огт тусгаагүй, харин Баян-өндөр сумын санхүүгийн албаны даргын үр дүнгийн гэрээнд тодорхой заалтууд тусгагдсан боловч биелэлт хангалтгүй, биелэлтийг гаргахдаа тоон үзүүлэлтээр огт илэрхийлээгүй нь уг ажлыг бодитой хангалттай хийсэн эсэх, тодорхой ахиц дэвшил гарсан эсэх нь тодорхойгүй байна.

Тухайлбал: Нэгжийн ажил үйлчилгээ 1.1.1-т Иргэд болон, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх, судлах, холбогдох албан тушаалтанд уламжлах гэж тусгасан. Баян-өндөр сумын санхүүгийн албаны ирүүлсэн үр дүнгийн гэрээний биелэлт нь үнэлгээ тавигдаж дарга ажилтны гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй баримт ирүүлсэн байна.



**БҮЛЭГ Б. Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй, хяналтын үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.**

***Б.1 Төрийн сангийн төлбөр тооцоог хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа боловч алдаа, дутагдал гарсан байна.***

**Б.1-1 Гүйлгээ хүлээн авах цагийн хуваариас шалтгаалан төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх нөхцөлийг хязгаарласан, төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

Аймгийн хэмжээнд төрийн сангийн төлбөр тооцоог 4 төрийн сангийн мэргэжилтэн гүйцэтгэж 2017 онд нийт 32,957 гүйлгээний 155,5 тэрбум төгрөгийн зарлага гарсан байна.

Төрийн санд байршсан орлогын 51, төсвийн байгууллагын 101, нэмэлт санхүүжилтийн 94, ахмадын сангийн 39, бусад 34 дансаар санхүүгийн төлбөр тооцоог гүйцэтгэн явуулж байна.

Төрийн сангийн гүйлгээг төрийн сангийн мэргэжилтнүүд зохих журмын дагуу хийдэг боловч 2015 онд ЗГ-ын 24 тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.6-д төлбөрийн хүсэлтийн ТТ-1 маягт нь дараах мэдээллийг агуулна 7.6.9-д " төлбөрийн нийт дүн, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллын нэр код болон үнийн дүнгийн задаргаа" гэж заасан бол Эгшилэн соёлын төв, Орхон ХАА-н МСҮТ, Жаргалант сумын ЗДТГ, ИТХ, сургууль, цэцэрлэгүүд төлбөрийн хүсэлтэд хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын нэрийг бичдэггүй, зөвхөн код бичиж ирүүлсэн байна.

Мөн Жаргалант суманд 2017/06/22-нд бичигдсэн төлбөрийн хүсэлтийг 2017/06/29-нд баталгаажуулан гүйлгээг хийсэн нь ТСҮА-ны журмын 8.2 заалтыг зөрчсөн байна. 2017/12/23-нд 757.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн хүсэлтийг гүйлгээ хийсэн мэргэжилтэн гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулаагүй нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь төлбөрийн хүсэлтийн 1-р гарын үсгийг дардсаар хэрэглэсэн нь Архивын ерөнхий газрын даргын тушаалаар 2009 онд батлагдсан “ Архив албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”- ын 2.3.11-т “Мөнгө-санхүүгийн холбогдолтой баримт бичигт байгууллагын дарга болон ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурна, Олон хувиар үйлдэн шуурхай хүргүүлж буй төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөр, урилга, мэндчилгээ зэрэг баримт бичигт гарын үсгийн дардас, эсвэл цахим гарын үсэг хэрэглэж болно. Харин тэдгээрийн эх хувь дээр албан ёсны гарын үсэг зурна ” гэсэн заалтыг зөрчин төрийн сангийн мэргэжилтэн гүйлгээг хийж, дотоод хяналт хариуцсан ажилтан хянаж баталгаажуулсан байна.

Мөн Унага цэцэрлэгийн 2017/11/27-ны өдрийн 210902 зардлын ангиллаас гарах 0.09 сая төгрөгийн гүйлгээг 210401-с, 2017/11/28-ны 210102 зардлын ангиллаас бичигдсэн 4.2 сая төгрөгийн гүйлгээг 210101-с гаргаж баталгаажуулсан байна.

Аймгийн хэмжээнд төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2017 онд 2,218 орлого бууруулсан гүйлгээ хийгдсэн бөгөөд төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.12-т “Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ажлын 3 хоногийн дотор Төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана” гэсэн заалтыг төсвийн байгууллагын нягтлан бодогч нар хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал аймгийн 2017 оны 02,11,12 дугаар сарууд, Жаргалант сумын 2017 оны 01,02,06,07,11,12-р саруудын орлого бууруулах нийт 270.9 сая төгрөгийн 257 гүйлгээнээс 181.6 сая төгрөгийн 131 гүйлгээг 3 хоногийн дотор буцаан шилжүүлээгүй байна.

Иймд төрийн сангаас төсвийн нягтлан бодогч нарыг зөвлөгөө арга зүйгээр хангаж, дансны хуулгыг тогтмол хянаж тодорхой бус болон орлого бууруулах гүйлгээг журамд заасан хугацаанд төрийн санд мэдэгдэж буцаан шилжүүлж байх шаардлагатай байна.

Жаргалант сумын төрийн сангийн гүйлгээг түүвэрлэн үзэхэд 2017 оны 12 сард хийгдсэн 0.7 сая төгрөгийн 3 гүйлгээ нь төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг тамга тэмдгээр баталгаажаагүй нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.6-т “Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад 1 хувийг өгнө. Төлбөрийн хүсэлтийн 1 хувь Төрийн санд үлдэнэ” заалтыг зөрчсөн байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.10-т “Төсвийн байгууллагын ТТ-1, ТТ-2 маягтаар бичигдсэн төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 хоногт хүчинтэй” гэж заасан байтал 2017 онд 16.2 сая төгрөгийн 8 гүйлгээг 3 хоногийг хэтэрсэн байхад хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд 69 алдаатай /хасах/ гүйлгээ хийгдсэнээс 8 сард хийгдсэн 17 гүйлгээ нь хамгийн өндөр бөгөөд нийт алдаатай гүйлгээний 24.64%-ийг эзэлж байна.

Аудитын түүвэрт хамрагдсан баримтад 22-р цэцэрлэгийн зарлагын гүйлгээг 2 удаа гаргасан боловч залруулгын хасах гүйлгээний мемориалын баримтыг 21-р цэцэрлэгийн данснаас гаргасан мэтээр хавсаргасан байна.

Мөн аймгийн төрийн сангийн ажлын цагийн хуваариар өглөө 8.00-10.30 цаг, өдөр 14.00-15.30 цаг хүртэл төлбөрийн хүсэлтийг хүлээн авч ажилладаг бөгөөд сарын эцэст сар бүрийн 28-аас хойш гүйлгээ авдаггүй байна. Төрийн сангийн мэргэжилтнүүд нь өдөрт өглөөд 2 цаг 30 минут, өдөр 1 цаг 30 минут нийт 4 цагийг төлбөрийн хүсэлтийг хүлээн авч гүйлгээ хийхэд зарцуулж байна.

Аудитын явцад төрийн сангийн үйл ажиллагааны талаар төсвийн байгууллагын нягтлан бодогч нараас авсан судалгаанаас үзэхэд Харилцагчдад одоо байгаагаас илүү шуурхай үйлчилгээ үзүүлэх боломж бий юу? Гэсэн асуултад нийт судалгаанд

хамрагдагсдын 38% / боломж бий/ гэж хариулсан бөгөөд гүйлгээний цагийг хязгаарлахгүй, гүйлгээг цаг харгалзахгүй авах гэсэн хүсэлтийг бичсэн байна.

Иймд өдөрт хийгдэх гүйлгээ бүрийг цаг харгалзахгүй хүлээн авч, нягтлан бодогч нарт дараалал үүсгэхгүй байх талаас нь анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад төсвийн нягтлан бодогч нараас авсан судалгааг хавсралт №1-оор оруулав.

**Б.1-2 Аймгийн төрийн сан нь харилцах данс болон кассын дансны үлдэгдлийг бүрэн тооцоо нийлээгүй, төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсын үндэслэх баримтыг тулгаж хянасан талаарх тэмдэглэлийг хийгээгүй байна.**

Орхон аймгийн төрийн сан мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнадаг байна. Үүнд:

- Төрийн сангийн харилцахын үлдэгдэл, байгууллага, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл;

- Кассанд байгаа бэлэн мөнгө.

2017 оны байдлаар төсөвт байгууллагуудын арилжааны банканд байрших кассын, ӨЭМТ, Эрдэнэт –Ус ДТС ОНӨХК, ОНӨҮГ-уудын харилцахын нийт 99 данс бүртгэлтэй байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар нийт 433.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тэдгээр байгууллагуудаас 16 байгууллага нь төрийн санд тооцооны үлдэгдлийг баталгааг гаргаж өгсөн байна.

Харин орон нутгийн нэгдсэн тайланд санхүүгийн тайлан нь нэгтгэгддэггүй босоо тогтолцоотой 28 байгууллагын арилжааны банканд байрших кассын дансны судалгаа, мэдээлэл аймгийн төрийн санд байдаггүй, түүнд тавих хяналт дутмаг байдаг байна. Иймд орон нутгийн нэгдсэн тайланд нэгтгэгддэг төсвийн байгууллага болон ОНӨҮГ, ӨЭМТ зэрэг байгууллагуудтай жил бүр арилжааны банкны дансан дахь үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, босоо тогтолцоотой байгууллагуудын арилжааны банкны судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэж шинэчлэж байх шаардлагатай байна.

Аймгийн төрийн санд нийт 319 данс бүртгэлтэй бөгөөд үүний 51 данс нь орлогын болон татан төвлөрүүлэлтийн данс, 235 нь төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн, ахмадын данс, 17 нь төсөл, тусгай сангийн данс, 9 тусгай шилжүүлэг, санхүүжилтийн данс, 7 нь хөрөнгө оруулалтын данс бүртгэлтэй байна.

2017 оны байдлаар дээрх дансдын тооцоо нийлж баталгаажуулсан байдлыг үзэхэд зарлагын 268 данснаас 170 данс буюу 63.4 хувь нь тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

Аймгийн төрийн сан нь Төрийн банканд дахь 340500324001 тоот дансанд 97.6 сая төгрөгийг байршуулж 2017 онд 9.8 сая төгрөгийн хүүг 340500404007 дансаар дамжуулан авч, тус орлогыг ерөнхий орлогын данс хаасан байна.

Төрийн сангийн мэргэжилтнүүд нь гүйлгээг хянаж гүйцэтгэхдээ төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсын үндэслэх баримтыг тулгаж хянасан талаарх

тэмдэглэлийг хийдэггүй, нягтлан бодогчид төлбөрийн хүсэлтийн үндэслэх баримтын нэр, огноо, дугаарыг оновчтой, зөв бичдэггүй, түүнд тавих хяналт сул байна.

Цаашид төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсын үндэслэх баримтыг жагсаалт бүрээр тулгаж, төлбөрийн хүсэлтэд тэмдэглэж /чеклэж/, үндэслэх баримтанд аль нь байсан, аль баримт нь байгаагүй талаар тэмдэглэж, Сангийн сайдын 2016 оны 431-р тушаалаар батлагдсан “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар” –ыг хэрэгжүүлж ажиллах, нягтлан бодогч нарт үндэслэх баримтыг үнэн зөв илэрхийлэн бичихийг шаардах, хэрхэн бичих талаар аргазүйн зөвлөгөөг тогтмол өгч, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### **Б.1-3 Төсвийн хэрэгжилтийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд холбогдох ажилтнуудын ажлын хариуцлага сул, тэдгээрт тавих хяналт хангалтгүй байна.**

Аймгийн ИТХ-н 2017 оны 12-р сарын 01-ны өдрийн ээлжит 9-р хурлын 9/02 дүгээр тогтоолын дугаар хавсралтуудаар хөрөнгө оруулалтын тодотгосон төсвийг баталсан байна. 2017 онд хөрөнгө оруулалтын 120 ажилд 8,973.8 сая төгрөг, шилжих хөрөнгө оруулалтын 113 ажилд 5,926.9 сая төгрөг, авто замын сангаас санхүүжих хөрөнгө оруулалтын 7 ажилд 607.6 сая төгрөг, ОНХСангаас санхүүжигдэх 16 ажилд 2,151.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тус тус тодотгон баталсан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 2,308.0 сая төгрөгийг Орхон аймгийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлж, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн долоон ажилд 552 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгосон байдлыг тулгахад төрийн сангийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Мон левзия ХХК-д ЭМТ-ын тоног төхөөрөмжийн 69.8 сая төгрөгийг 2017.10.20-нд олгосон байтал түүнийг өвчтэй байх хугацаанд ажлыг нь түр орлож байсан төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн 2017.12.25-нд дахин шилжүүлж авлага үүсгэж 2018 онд төлөгдсөн байна. Энэ нь төрийн албан хаагчдын хоорондын уялдаа холбоо, хариуцлагагүй байдлаас үүссэн байна.

Орхон аймгийн БСУГ-аас 2017 онд хувийн хэвшлийн 7-н сургуульд 549.5 сая төгрөг, 8-н цэцэрлэгт 574,2 сая төгрөгийн нийт 1,123.7 сая төгрөгийг, ЭМГ-аас өрхийн эрүүл мэндийн 2 нэгдсэн төв, 6-н өрхийн эмнэлэгт 2017 онд 1,331.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Аудитын явцад хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт олгосон байдлыг шалгахад хувийн хэвшлийн 7-н сургуульд 14.3 сая төгрөгийг, 5-н цэцэрлэгт 3.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байх тул БСУГ-т хариуцуулан төлбөрийн акт тогтоолоо.

Харин өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2017 оны санхүүжилтийг тооцож олгохдоо тухайн өрхийн эмнэлгийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын тоонд үндэслэлгүйгээр 2016 оны санхүүжилтийн дүнд эзлэх хувиар тооцож олгосноос нийт 7.7 сая төгрөгийг нэг хэсэгт нь илүү, нэг хэсэгт нь дутуу тооцож олгосон зөрчил илэрлээ. Үүнд:


1. Энхжин Мандирваа ӨЭМТ-д 3.4 сая төгрөг, Нийцэл ӨЭМТ-д 2.2 сая төгрөг, Мөнхийн гэгээ ӨЭМТ-д 0.01 сая төгрөг, Учралт баяр ӨЭМТ-д 2.1 сая төгрөгийг дутуу,
2. Үйлсбадрах ӨЭМТ-д 0.3 сая төгрөг, Мөнхсүндэрэл ӨЭМТ-д 6.2 сая, Анхны – Оч ӨЭМТ-д 0.7 сая төгрөг, Мэндцэцэн ӨЭМТ-д 0.5 сая төгрөг тус тус илүү санхүүжигдэж олгогдсон байх тул зөрчил арилгуулах албан шаардлагыг ЭМГ-т хариуцуулан хүргүүлэв.

Дээрхээс үзэхэд хувийн байгууллагуудын санхүүжилтийг холбогдох салбарын сайдын тушаалаар батлагдсан норм, аргачлалын дагуу үнэн зөв тооцож олгодоггүй, тухайлбал БСУГ-аас хувийн сургууль, цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтийг сар бүр хүүхэд өдрөөр хянадаггүй байна.

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тус дансанд 2017 онд 1,938.1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 154.3 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Орлого, зардлыг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөгөөр)



Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийн хүсэлтийг маягтын дагуу гаргаж төрийн сангаар холбогдох зардлын ангилалд эрхийг нээлгэж зарцуулдаг байна.

## **Б.2 ЗГСУМС нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.**

**Б.2-1 Системийг хэрэглэхэд ойлгомжтой боловч зарим дутагдалтай тал байна.**

Сангийн сайдын 2014 оны 95-р тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-аар зохицуулагдсан ажил

үүргийн эрхийн дагуу төрийн сангийн ажилтнууд тус тусийн ажил үүргийг гүйцэтгэж байна.

Төрийн сангийн төлбөр тооцооны системд аймгийн төрийн сангийн 5 /ерөнхий ня-бо, дотоод хяналтын мэргэжилтэн, төлбөр тооцооны мэргэжилтэн -3/, Жаргалант сумын төрийн сангийн 2 албан хаагч ажилладаг бол төсвийн төлөвлөлтийн фискал /fiscal/ программ болон төсвийн төлөвлөлтийн мэдээллийн системд төсвийн зарлагын мэргэжилтэн ажилладаг буюу нийт 8 албан хаагч ЗГУМС-тэй холбоотой ажилладаг байна.

Төрийн сангийн төлбөр тооцоонд Фрийбаланс /Freebalance/ программыг ашиглаж байгаад 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс Төрийн сангийн төлбөр тооцооны V7 программыг шинээр нэвтрүүлж эхэлсэн. Энэ нь өмнөх программтай харьцуулахад дараах давуу болон дутагдалтай талууд байна.

Үүнд: Байгууллагын төсвийг хянахад механик ажиллагаа ихтэй, нэг байгууллагын төсвийг харахын тулд ЭЗ-ийн ангилал бүрээр орж хардаг, үйлдэл ихтэй, мөн өмнө нь төлбөр тооцооны мэргэжилтэн гүйлгээ шивэх явцад тухайн зардлын төсөв хүрэлцэх эсэхийг шууд хянах боломжтой байсан бол одоо хянах боломжгүй, гүйлгээ шууд шивэгдээд дотоод хяналтын мэргэжилтэнд илгээгдээд, зөвхөн батлах явцад төсөв хүрэлцэхгүй байгаа нь мэдэгдэж, гүйлгээг буцааж цуцлах, гүйлгээ батлахад олон үйлдэл нэмэгдсэн, цаг хугацаа их шаарддаг зэрэг дутагдалтай талууд байна.

Фрийбаланс /freebalance/ программ нь данс нэр регистрийн дугаар зэргээс аль нэг нь буруу шивэгдэхэд хасах гүйлгээ буюу буцах гүйлгээ их гардаг байсан бол шинэ программ нь регистрийн дугаарыг шивэхэд дансны дугаар автоматаар гарч ирдэг болсноор данс андуурсан гүйлгээний тоо буурсан давуу талтай байна.

Эдийн засгийн ангилал болон бүлэг хооронд гүйлгэн зарцуулах боломж байдаг бөгөөд түүнийг баталгаажуулахаасаа өмнө буцаах боломжтой, өмнө нь шууд гараад хасах гүйлгээ болж харагддаг байсан бол шинэ программ цуцлах, засварлах гэсэн сонголттой учраас хасах гүйлгээ гарахгүй засварлагддаг болсон давуу талтай байна.

ЗГСУМС-д нэвтрэх эрхтэй хэрэглэгчдээс авсан санал асуулга, шалгах хуудас, ярилцлага зэргээс үзэхэд төрийн сангийн нэгдсэн тогтолцооны мэдээллийн систем нь тэдний хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

ЗГСУМС-ийн хэрэглэгчдээс авсан судалгаа, санал асуулга, шалгах хуудсыг доор харуулав.

Б.2-1-1

Асуулт, хариу бөглөх хэсэг	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу?	ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу?	ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?	Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?
----------------------------	--	--	---	---



	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй
Сонгосон хариултын доор "1"-ыг бөглөнө үү	4	4	0	7	1		1	4	3	2	4	2
Тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээл байвал дэлгэрэнгүй бичнэ үү.	Байгууллагын санхүүжилтийг нээхэд цаг их ордог. Олон үйлдэл хийдэг			Бүрэн хамарч чадахгүй байна			Сүлжээ саатах, доголдох. Программ удаан ачааллаж уншдаг. Хугацаа алддаг. Байгууллагын үлдэгдэл төсөв харах боломжгүй болсон			Программын ачааллыг бүрэн хангаж чаддаггүй, гацдаг. Хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай		

## Б.2-1-2

Асуулга	Системийн функционал администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж, эхлүүлж байна уу?			Танд зохих эрхийг бүрэн олгосон уу?			Системд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу олгосон уу?			Таны эрхийг хязгаарласан тохиолдол бий юу?			Системийн функционал администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу?			Таны эрхийг давхардуулсан ашигладаг хэрэглэгч байгаа юу?		
	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй
Сонгосон хариултын доор "1"-ыг бөглөнө үү	8			8			8			4	4	8				1		7

Дээрх судалгаанаас үзэхэд системийн тасалдалгүй, найдвартай ажиллагааг хангах, системийн засвар үйлчилгээ хийгдэх, түр тасрах бол урьдчилан мэдээлж байх, компьютерийн хүчин чадалтай холбоотой алдаа байгаа бол тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

### Б.2-2 ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үг шилжүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журмын 2-р бүлэгт төрийн сангийн мэргэжилтнүүдийг ээлжийн амралттай, түр чөлөөтэй болон ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үгийг түр хугацаагаар болон шинээр томилогдсон ажилтанд эрх шилжүүлэх асуудлыг зохицуулсан байдаг.

Тухайлбал тус журмын 2.4-д “Системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ээлжийн амралт, гадаад болон дотоод томилолт, хүүхэд асрах чөлөөтэй, түр хугацааны чөлөөтэй байх хугацаанд системийн нэр, нууц үгээ шилжүүлэх тохиолдолд харьяа нэгжийн удирдах албан тушаалтны холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн эрхийг шинэ хэрэглэгчид шилжүүлж, тухай бүр харьяа аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгээр мэдэгдэж байна. Хэрэглэгч системд нэвтэрсэн эхний үйлдлээр нууц үгийг шинэчилж сольсон байна”,

2.6-д “Тухайн төсвийн жилийн системийн хэрэглэгч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх тухай албан хүсэлтийг Төв төрийн санд аймаг, нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэс, сум, дүүргийн хэрэглэгчийн хувьд харьяа аймаг, нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулан, Төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс холбогдох тушаал, шийдвэрийн хуулбарын хамт ирүүлнэ. Системийн функционал администратор ирүүлсэн хүсэлтийг хянаж, хавсралт 2-оор батлагдсан маягтын дагуу Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн даргаар батлуулан, хэрэглэгчдийг системд бүртгэн оруулна,

2.7-д “Хэрэглэгчдийн нэр, нууц үгийг бусдад шилжүүлсэн тухай бүр энэ журмын хавсралтаар батлагдсан “Хэрэглэгчийн нэр, нууц үг шилжүүлэх маягт” /хавсралт-1/-ын дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв хөтлөн харьяа нэгжийн даргаар баталгаажуулж холбогдох тушаал, шийдвэрийн хуулбарын хамт хавсарган архивын нэгж үүсгэнэ” гэж тус тус заасан байна.

Аймгийн СТСХ-ийн хувьд ЗГСУМС-д нэвтрэх эрхийг ээлжийн амралттай, томилолттой, хүүхдээ харах болон түр хугацаагаар чөлөөтэй байх үед түр хугацаагаар хэрэглэгчийн нэр, нууц үг шилжүүлэх болон ажилтан ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн үед хуучин хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх асуудлыг журмын дагуу зохион байгуулаагүй, маягт 2-ыг буруу хэрэглэсэн, маягт 1-ийг хөтлөөгүй, холбогдох тушаал шийдвэрийг тухай бүр бүрэн гаргаагүй, архивын нэгж болгож хадгалаагүй байна.

Тухайлбал аймгийн санхүү төрийн сангийн төлбөр тооцооны хоёр мэргэжилтэн 2016 онд хүүхэд асрах чөлөө авсан байхад шинээр томилогдсон ажилтнуудад түр хугацаагаар хэрэглэгчийн нэр, нууц үг шилжүүлэх тушаал, шийдвэр гаргаагүй, маягт 1-ийг хөтлөөгүй, харин Сангийн яамны төрийн сангийн газарт системд нэвтрэх нэр, нууц үгийн эрхийг түр хугацаагаар шилжүүлэх албан тоот явуулсан байна. 2017 оны 03-р сард шинээр томилогдсон төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэнг системд бүртгүүлэх талаар албан тоот явуулаагүй, маягт 2-г хөтлөн СТСХ-ийн дарга баталгаажуулсан байна. Аймгийн төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтнүүдийг ээлжилж амраадаг тул ээлжийн амралттай үед системийн эрхийг түр хугацаагаар шилжүүлэх шаардлагагүй, үлдсэн мэргэжилтэн нь гүйлгээгээ хийдэг бол ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын мэргэжилтэнг ээлжийн амралттай үед 2017 онд системийн эрхийг түр хугацаагаар шилжүүлэх шийдвэр байхгүй байна. Харин 2018 оны 3-р сард аймгийн ЗДТГ-ын даргын А/29 тоот тушаалаар дотоод хяналтын мэргэжилтэнг 10 хоногийн сургалттай байх хугацаанд системийн эрхийг түр хугацаагаар шилжүүлэх эрхийг ерөнхий нягтлан бодогчид шилжүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд ЗГСУМС-д нэвтэрсэн хэрэглэгчийн мэдээллийг харуулбал:

№	Төрийн сангийн нэр	ЗГСУ МС -д нэвтрэх эрх	Ажил үүргийн хуваарь	2017 онд ЗГСУМС-д нэвтэрч ажилласан хэрэглэгчид			Тайлбар
				Овог	Нэр	Хамрах хугацаа	
1	Орхон төрийн сан	OR6	ТС-ийн мэргэжилтэн	Батмөнх	Мөнхцэцэг	2017.01.01 2017.12.31	Хүний оронд түр
2	Орхон төрийн сан	OR41	ТС-ийн мэргэжилтэн	Энхтүвшин	Цэнд-Аюуш	2017.03.13 2017.12.31	Шинээр томилогдсон
3	Орхон төрийн сан	OR3	ДХ-ийн мэргэжилтэн	Лхагва	Галсансайн хувьт	2017.01.01 2017.12.31	
4	Орхон төрийн сан	OR2	ТС-ийн мэргэжилтэн	Авирмэд	Отгонцэцэг	2017.01.01 2017.02.09	Хүний оронд түр
				Баттөр	Оюуннасан	2017.02.17 2017.12.31	
5	Орхон төрийн сан	OR1	Ерөнхий нягтлан бодогч	Сосор	Энхтүвшин	2017.01.01 2017.12.31	
6	Ор.Жаргалант сумын ТС	ORJA1	СА-ны дарга	Пүрэв	Буянбат	2017.01.02 2017.12.31	Шинээр томилогдсон
7	Ор.Жаргалант сумын ТС	ORJA2	ТС-ийн мэргэжилтэн	Бавуусүрэн	Отгонсүрэн	2017.01.01 2017.12.31	

**Б.3 Дотоод хяналтын үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.**

**Б.3-1 Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулсан боловч хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.**

Сангийн сайдын 2014 оны 65 тоот тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам” -ын 4.3-д заасны дагуу 2017 оны дотоод хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2017.02.15-ны өдрийн А/60 тоот захирамжаар баталгаажуулж, тухайн оны 5, 10 дугаар саруудад хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тус журмын 5.1-д заасны дагуу төрийн сангийн нэгжийн эрсдэлийн үнэлгээг журмын хавсралт 1-д заасан маягаар хийсэн бөгөөд эрсдэлийн үнэлгээгээр аймаг 33, Жаргалант сум 13, Баян-Өндөр сум 9 оноотой үнэлгээ хийгдсэн байна. Мөн хавсралт 2-д заасан төрийн сангийн нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг дотоод хяналт хариуцсан ажилтны хийсэн нь аймаг 2, Жаргалант сум 3, баян-өндөр сум 3 оноо авсан байна.

Эрсдэлийн үнэлгээ хийсэн байдлаас үзэхэд хавсралт 1-ийн нэгтгэлийн нийт оноо дутуу буруу татагдсан. Тухайлбал: Асуулт 16-д ЗГСУМС-д нэвтрэхдээ эрхээ бусдад шилжүүлэх тохиолдол гардаг уу гэсэн асуултанд аймаг 4, Жаргалант сум 4 оноо тус тус авсан байхад нэгтгэлийн хүснэгт 0 оноотой байна.

Мөн хавсралт 1-ын дотоод хяналтын орчны нийт эрсдэлийн түвшинг гаргахдаа аймгийн төрийн сангийн үнэлгээ 39 гарах байтал 33 гаргаж буруу дүгнэсэн байна. Тус журмын 5 дугаар хавсралтад зааснаар төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний нэгдсэн хүснэгтийг хийхдээ хавсралт 1-ын асуулт 19-ын оноог

буруу тавьж нэгтгэсэн. Хавсралт 2-ын жаргалант сум 3 оноо авсан байхад 2 оноо авсан гэж буруу нэгтгэсэн байна.

Аймгийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан ажилтан нь төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг хянаж баталгаажуулдаг байна. Тухайн онд дотоод хяналтын журмын дагуу төлөвлөгөөт хяналтыг аймгийн төрийн сан болон сумдын төрийн санд 1 удаа хэрэгжүүлэн тайлан бичиж төрийн сангийн нэгжүүдэд зөвлөгөө зөвлөмж хүргүүлсэн байна.

Тухайлбал: Жаргалант сумын ЗДТГ-т 2017/11/08-ны 6/2802 тоот, Баян-Өндөр сумын ЗДТГ-т 2017/11/08 6/2801 тоот албан бичгээр илэрсэн зөрчил болон түүнийг арилгах талаар тус тус хоёр, хоёр зөвлөмж, аймгийн төрийн санд хяналт хэрэгжүүлсэн тайлангаар 15 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн боловч тэдгээрийн хэрэгжилт бүрэн хангагдсан эсэх талаар авч хэрэгжүүлсэн ажил байхгүй байна.

Түүнчлэн эрсдэлийн үнэлгээгээр өндөр оноо авсан албан хаагчдын тогтвор суурьшилтай ажилладаг эсэх талаар хяналтын тайланд тусгаагүй, тэр чиглэлээр шалгаагүй нь эрсдэлийн үнэлгээг хяналтын чиглэлтэй уялдуулахгүй байгааг харуулж байна.

### **Б.3-2 Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.**

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь төрийн сангийн мэргэжилтний гүйлгээг хянаж баталгаажуулдаг байна.

2017 онд төрийн сангийн төлбөр тооцооны программаар нийт 155,556.1 сая төгрөгийн 32,957 гүйлгээг төрийн сангийн 4 мэргэжилтэн гүйцэтгэж 1 дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн болон сумын санхүүгийн албаны дарга нар хянаж баталгаажуулсан байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 2.1.3-т “тулган баталгаажуулах арга гэж дотоод хяналтыг хэрэгжүүлж буй албан тушаалтан түүврийн аргаар сонгон авсан нэг эсвэл хэдэн ажил, холбогдох үндэслэх баримттай нь тулган хянан үзэхийг хэлнэ” гэж заасан байтал дотоод хяналт хариуцсан ажилтан нь тулган баталгаажуулах аргаар түүвэрлэн хяналт хэрэгжүүлээгүй, энэ талаар дотоод хяналтын тайланд огт тусгагдаагүй байна.

Иймд дотоод хяналтын төлөвлөгөөнд байгууллагуудаас түүвэрлэн үндэслэх баримттай нь тулган баталгаажуулах талаар тусгаж хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

**ДҮГНЭЛТ:**

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг холбогдох хуульд бүрэн тодорхойлсон байна.
- Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжуудад бусад эрх зүйн актуудад тусгагдсан харилцах дансыг хаах талаархи зохицуулалтууд хэрхэн үйлчлэх, яаж зохицуулах талаар тодорхой тусгагдаагүй байна.
- Төрийн сангийн үйл ажиллагааны талаар журам зааварт хараат бус байдлыг хангаж ажиллах талаар тодорхой тусгаагүй, дүрэм журмын зарим зохицуулалт оновчтой бус байна.
- Баян-Өндөр сумыг төрийн сангийн төлбөр тооцооны программтай болгож, чиг үүргийн дагуу ажиллуулаагүй, ажлын ачааллыг тэнцвэржүүлээгүй байна.
- Ажлын байрны тодорхойлолтыг жишиг зааварт нийцүүлэн боловсруулаагүй байна.
- Жаргалан сумын санхүүгийн албаны нягтлан бодогчийг албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр давхар томилсон нь ажлын хяналт алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Гүйлгээ хүлээн авах цагийн хуваариас шалтгаалан төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх нөхцөлийг хязгаарласан, төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн төрийн сан нь харилцах данс болон кассын дансны үлдэгдлийг бүрэн тооцоо нийлээгүй, төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсын үндэслэх баримтыг тулгаж хянасан талаарх тэмдэглэлийг хийгээгүй байна.
- Төсвийг хэрэгжилтийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд холбогдох ажилтнуудын ажлын хариуцлага сул, тэдгээрт тавих хяналт хангалтгүй байна.
- Системийг хэрэглэхэд ойлгомжтой боловч зарим дутагдалтай тал байна.
- ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үг шилжүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулсан боловч хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.
- Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

**ЗӨВЛӨМЖ:**

Аудитын илрүүлэлт, аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**Аймаг, сумдын ЗДТГ-т**

- ✓ Холбогдох журам зааварт нийцүүлэн аймгийн СТСХ-ын болон Жаргалант сумын санхүүгийн албаны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, үр дүнгийн гэрээг уялдуулах.
- ✓ Баян-Өндөр сумын санхүүгийн албаны 2 ажилтанг чиг үүргийн дагуу ажиллах боломжийг хангах талаар арга хэмжээ авч ажиллах.
- ✓ ТЗ-ны албан тушаалын ангилалд хамаарах ажлын байрны тодорхойлолт болон өдөр тутамд гүйцэтгэж буй ажил, чиг үүрэг нь нэг ижил төрийн сангийн 3 мэргэжилтний 1-ийг ТҮ-ний орон тоо, албан тушаалд баталж, үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байгаа зөрчлийг арилгах.

**Аймгийн СТСХ-т:**

- ✓ Төрийн сангаас төсвийн нягтлан бодогч нарыг зөвлөгөө арга зүйгээр хангаж, дансны хуулгыг тогтмол хянаж тодорхой бус болон орлого бууруулах гүйлгээг журамд заасан хугацаанд төрийн санд мэдэгдэж буцаан шилжүүлж байх, хяналтын хуудасны үндэслэх баримтыг үнэн зөв бичихийг шаардах, төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсын үндэслэх баримтыг жагсаалт бүрээр тулгаж, төлбөрийн хүсэлтэд тэмдэглэж /чеклэх/ байх.
- ✓ Дотоод хяналтын төлөвлөгөөг журмын дагуу эрсдэлд суурилан боловсруулж, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг тооцож байх.
- ✓ Аймгийн хэмжээнд төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын бүх харилцах болон арилжааны банкин дахь картан дансны нэгдсэн судалгаатай болж, жил бүрийн эцэст дансны үлдэгдлийн баталгааг авч мэдээллийг шинэчилж байх.
- ✓ ЗГСУМС-д хэрэглэгчийн нэр, нууц үгийг түр шилжүүлэх болон шинээр бүртгүүлэх тухай бүр тушаал шийдвэрийг гаргуулж, холбогдох материалыг журмын дагуу бүрдүүлж архивын нэгж үүсгэх. Төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх боломжтой уялдуулан гүйлгээ хүлээн авах цагийн хуваарийг тогтоох.

**Мэдэгдэл:** Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож 2019 оны 06 дугаар сарын 05-ний дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.





## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,  
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,  
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621  
И-мэйл: info@erdenet.mn

2018.11.05 № 6/2813  
танай -ны № -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас 2017 оны "Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн"-д хийгдсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Уг тайлангийн төсөлд нэмэх саналгүй, аудитаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.



САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.БЯМБАЦЭЦЭГ

D:/My documents/A-5. doc  
030106323



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/29

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаал, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн аудитын тайлан /САГ-2018-03-СА/-г баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /Д.Соёлчхүү/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Н.Бямбацэцэг/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргын тамгын газарт тус тус хүргүүлсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /Г.Оргилмөрөн/ нарт даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ц.НАРМАНДАХ

D:\my doc \bichig heregl\ tushaal \ 2018.doc



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, Тэргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр  
сарын 05-ны өдрийн 29 дугаар тушаалын  
хавсралт



“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн  
төлбөр, зөрчлийн жагсаалт

/сая.төгрөг/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
56/59- САГ- 2018-03- СА	Хувийн сургууль, цэцэрлэгийн 2017 оны хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг 17,989.1 мянган төгрөгөөр илүү олгосон зөрчил илэрлээ.	БСУГ	Дарга,  Төсвийн мэргэжилтэн	Ж.Бат- Амгалан,  Ч.Наранцэцэг	17,9	
69/77- САГ- 2018-03- СА	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2017 оны санхүүжилтийг тооцож олгохдоо тухайн өрхийн эмнэлгийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын тоонд үндэслэлгүйгээр 2016 оны санхүүжилтийн дүнд эзлэх хувиар тооцож олгосноос нийт 7,757.8 мянган төгрөгийг нэг хэсэгт нь илүү, нэг хэсэгт нь дутуу тооцож олгосон зөрчил илэрлээ.	ЭМГ	Дарга,  Нягтлан бодогч	Ц.Мөнхцэцэг,  Н.Чулуун- Эрдэнэ		7.7
	<b>Нийт дүн</b>				<b>17.9</b>	<b>7.7</b>

Хавсралт № 01

**ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ХУУДАС**

/ Төсвийн байгууллагын нягтлан бодогчдоос авсан /

№	Асуулга	Санал өгсөн байдал						Нийт өгсөн саналын тоо	Тайлбар
		Тоогоор			Хувиар				
		Тийм	Үгүй	Хоосон	Тийм	Үгүй	Хоосон		
1	Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжихгүй хууль тогтоомжийн заалтууд бий юу?	3	31	0	9%	91%	0%	34	Жижиглэн худалдаа эрхэлдэг хүмүүс и-баримт олгодоггүй. Зарим үед худалдан авалт хийхэд хүндрэлтэй байдаг
2	Төрийн сангийн үйл ажиллагаанд хоорондоо уялдахгүй байгаа болон зөрчилтэй хууль тогтоомжийн заалтууд бий юу?	2	32	0	6%	94%	0%	34	
3	Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй эрх зүйн актуудад шинэчлэх сайжруулах шаардлагатай заалт байна уу? Тийм бол саналаа бичнэ үү	4	29	1	12%	85%	3%	34	Жижиг мөнгөн сан буюу бэлнээр гаргах мөнгөний хэмжээ
4	Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага байна уу?	3	31	0	9%	91%	0%	34	
4	Ямар чиг үүргийг шинэчлэн сайжруулах шаардлагатай талаар саналаа бичнэ үү	1	23	10	3%	68%	29%	34	Төрийн сангийн гүйлгээний 2 компьютер хүчин чадал сайжруулах. Интернэт гүйлгээ
5	Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэж байна уу?	27	7	0	79%	21%	0%	34	
6	Төрийн сангаар хийгдсэн гүйлгээ саатаж байсан удаа байгаа юу?	4	29	1	12%	85%	3%	34	Баталгаажуулалтад сангийн яам удаашруулдаг. Программ шинэчлэлтэй холбоотой. Сүлжээ байхгүй үед яаралтай гүйлгээ
7	Харилцагчид үйлчилгээ авахын тулд найр тавьж байсан тохиолдол бий юу?	0	34	0	0%	100%	0%	34	
8	Төрийн сангийн газраас харилцагчиддаа арга зүйн зөвлөмж өгдөг үү?	29	5	0	85%	15%	0%	34	Аргазүйн зөвлөгөө бага өгдөг. Гүйлгээн дээр зөвлөгөө өгдөг
9	Төрийн сангийн үйл ажиллагаанд хүнд суртал, харилцааны асуудал гардаг уу?	2	31	1	6%	91%	3%	34	Санхүүжилтийн эрх нээх
10	Харилцагчдад одоо байгаагаас илүү шуурхай үйлчилгээ үзүүлэх боломж бий юу? Саналаа бичнэ үү	13	20	1	38%	59%	3%	34	Цагийн хязгаар тавихгүй байх Гүйлгээг цаг харгалзахгүй авах

Танд Төрийн сангийн тогтолцоог сайжруулах санал байвал бичнэ үү.....

Төрийн сангийн шинэ хууль тогтоомжийн талаар сайн сурталчлах

Программын шинэчлэл хийгдсэн тул сайжирсан гэж бодож байна  
Программын шинэчлэлийг хийх хурд багатай байгаагаас ачаалал их харагддаг  
Сангийн сайдын 55 журмын олон утгыг ойлгомжтой, тодорхой болгох  
Баян-Өндөр суманд төрийн сангийн салбар байгуулах  
Төрийн сангийн одоо мөрдөж байгаа цагийн хуваарийг дахин нэг харж үзэх

Танд одоо байгаагаас илүү шуурхай үйлчилгээ авах санал байвал бичнэ үү .....

Орхон аймгийн Төрийн сангийнхан мэдээллээр байнга хангаж байх  
Гүйлгээ хурдан шуурхай харилцагчийн дансанд ордог болсон  
Төрийн сангийн гүйлгээний компьютер хүчин чадал сайжруулах  
Гүйлгээний мэргэжилтэн  
нэмэгдүүлэх  
Үйлчилгээ хэвийн жигд үйлчилдэг

Боловсролын газрын ч юмуу мэргэжилтний заавраар зарим зардлаас гүйлгээ хийхгүй байх ч гэдиймуу  
гүйлгээнд хориг саад, зардлын ангиллаар саад тавьж буй нь буруу гэж бодож байна. Сайдан хэмнэлтийн  
горимын талаар мэдэгдэл байгаа ч хэт туйлширч байна.

Интернетээр гүйлгээ хийдэг болох  
Цагийн хязгааргүй байх, Ажлын өдөр 8-16.30 хүртэл ажиллах